



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/185

Мөрөн

Эрх шилжүүлэх тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Төрийн үйлчилгээ иргэнд” аймгийн хөтөлбөрийн хүрээнд Мөрөн сумын багт ажиллах хэсгийн ахлагч нарын урамшуулалын зардалд хувиарлагдсан 60,0 сая төгрөгийг Мөрөн сумын багуудад ажиллах хэсгийн ахлагч нарын урамшуулалд зарцуулах эрхийг аймгийн Засаг даргаас Мөрөн сумын Засаг дарга/Ц.Гансүх/-д шилжүүлсүгэй.

2. Хэсгийн ахлагч нарыг сонгож, гэрээ байгуулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан тухай мэдээ, тайланг тогтоосон хугацаанд ирүүлж байхыг Мөрөн сумын Засаг дарга/Ц.Гансүх/-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга / Г.Сувд /-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР